



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГЭРЭЭНИЙ ХУГАЦААГ СУНГАН АЖИЛ УДААШИРЧ, САНХҮҮЖИЛТИЙГ
БҮРЭН АШИГЛАХГҮЙ БАЙГАА НЬ ГЭРЭЭНД АЛДАНГИЙН ХЭМЖЭЭГ
ӨНДӨР ТУСГАСАНТАЙ ХОЛБООТОЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СБА-2025/06-16-ШТА-ГА

Баруун-Урт 2025 он



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Болдбаатар

Утас: 70512127 Цахим хаяг: oyunboldg@audit.gov.mn

Аудитор Э.Алтансүх

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Аудитор Б.Ганцэцэг

Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
БҮЛЭГ 1. МАГАДЛАЛЫН ДҮГНЭЛТ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТГҮЙ, ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮД УЛСЫН ТӨСӨВТ БАТЛАГДСААР БАЙНА.....	5
1.1. Сүхбаатар аймагт 2024 онд хэрэгжүүлэхээр улсын төсөвт шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 31 төсөл, арга хэмжээний 16 төсөл, арга хэмжээ нь “Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдаагүй байна.....	5
1.2. Сүхбаатар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд тусгагдаагүй 13 төсөл арга хэмжээ улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад орж, батлагдсан байна.....	5
1.3. Төсвийн тухай хуульд заасан хувь хэмжээнээс бага санхүүжих дүнтэй 2 төсөл арга хэмжээ, магадлалын ерөнхий дүгнэлтгүй 12 төсөл, арга хэмжээ, техникийн тодорхойлолтгүй 4 төсөл арга хэмжээг төлөвлөж, улсын төсөвт батлагдсан байна.....	6
1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1 дэх заалттай нийцэхгүй 2 төсөл арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.....	7
БҮЛЭГ 2. АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД НЭГЖ ҮНЭЭР ИЛЭРХИЙЛСЭН ТӨСӨВТ ӨРТГИЙГ АШИГЛАХГҮЙ БАЙГАА НЬ ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙГ ШАЛГАРУУЛАХАД НӨЛӨӨЛСӨН БАЙНА.....	8
2.1. Магадлалын дүгнэлтгүй төсөл, арга хэмжээг улсын төсөвт баталсан нь худалдан авах ажиллагаа хойшлох, хэрэгжилтэд хугацаа алдах эрсдэлтэй байна.	8
2.2. Тендерийн баримт бичигт алдангийн хувь хэмжээг оновчтой тусгаж, тендерийн төсөвт материал, тээвэр, машин ашиглалтын шууд зардлын төсвийг ажлын үе шат бүрээр тусгуулж, хяналтын төсвийг цахим системд байршуулах шаардлагатай байна.....	9
2.3. Тендерийн төсвийг нэгж үнээр гаргаж ирүүлэх шаардлагыг хангаагүй тендерт оролцогчдыг шалгаруулсан зөрчил нийтлэг байна.....	10
БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ БОДИТОЙ, ҮНЭН ЗӨВ БАТАЛГААЖУУЛААГҮЙН УЛМААС ГҮЙЦЭТГЭЛЭЭС ИЛҮҮ САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ЗӨРЧИЛ НИЙТЛЭГ БАЙНА.	11
3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн олгохгүй байна.....	11
3.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй 6 төсөл арга хэмжээний 8 гэрээний хугацаа сунгагдсан байна.....	14
3.3. Улсын комисс нь үүрэг даалгавар биелээгүй байхад акт, дүгнэлт үйлдэж авто зам, барилга байгууламжийг хүлээн авч байгаа нь чанарт сөргөөр нөлөөлж байна.	16
3.4. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас шийдвэр ирээгүй шалтгаанаар зарим төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байна.....	18
Холбогдох байгууллагын санал:	19
Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:	21
ДҮГНЭЛТ: 21	
ЗӨВЛӨМЖ: 21	
Үндэсний аудитын газарт хүргүүлж буй санал:	22

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
УИХ	Улсын Их хурал
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Гэрээний хугацаа сунгасан төсөл арга хэмжээ	15
Хүснэгт 2	Улсын комиссоос өгсөн үүрэг даалгавар, түүний биелэлт	16

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит үндэслэл, эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалтыг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолын дагуу хийв.
Аудитын зорилт	Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг АИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтыг 2024 онд хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч болон тэдгээрийн харьяа байгууллагууд, захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэгч байгууллага болон зураг төслийн компаниуд, холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Болдбаатар, аудитор Э.Алтансүх, Б.Ганцэцэг нар 2025 оны 01 сарын 20-ны өдрөөс 4 сарын 18-ний өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. МАГАДЛАЛЫН ДҮГНЭЛТ, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТГҮЙ, ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНҮҮД УЛСЫН ТӨСӨВТ БАТЛАГДСААР БАЙНА.

1.1. Сүхбаатар аймагт 2024 онд хэрэгжүүлэхээр улсын төсөвт шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 31 төсөл, арга хэмжээний 16 төсөл, арга хэмжээ нь “Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдаагүй байна.

1.1.1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд Сүхбаатар аймагт нийт 41 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсанаас шинээр хэрэгжих 31, өмнөх оноос шилжсэн 10 төсөл, арга хэмжээ байна.

1.1.2. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 39 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 31 төсөл, арга хэмжээнээс зөвхөн 15 нь тусгагдсан бөгөөд үлдсэн 16 төсөл, арга хэмжээ нь тус төлөвлөгөөнд тусгагдаагүй байна. Үүнд: тусгай зориулалтын байгууламж худалдан авах, засвар хийх, Алтан овооны хамгаалалтын хашаа, Дарьганга зуслангийн шинэчлэл, УЦУОШТ-ийн болон өртөөний засвар, харилцаа холбооны дэд бүтэц, аймгийн болон сумын хатуу хучилттай авто зам, соёлын төв, эмнэлгийн төвийн барилга, прокурорын барилга зэрэг төсөл, арга хэмжээ багтаж байна.

1.1.3. “Монгол Улсын 2021–2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 2024 оны санхүүжилтийн хуваарьт тусгагдсан зарим төсөл, тухайлбал ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн барилга, харилцаа холбооны чанар, хүртээмжийг сайжруулах, махны үйлдвэр, хорио цээрийн бүс бүхий цогцолбор байгууламж зэрэг төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баталсан байна. Харин бусад батлагдсан төсөл, арга хэмжээ нь тус хөтөлбөрт тусгагдаагүй байна.

1.2. Сүхбаатар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд тусгагдаагүй 13 төсөл арга хэмжээ улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад орж, батлагдсан байна.

1.2.1. Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 295-р дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ын дагуу Сүхбаатар аймагт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 228,967.04 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2024 онд 135,368.59 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 28 төсөл, арга хэмжээний саналыг Монгол улсын 2024 оны төсвийн төсөлд тусгуулахаар хүргүүлсэн байна.

1.2.2. Дээрх журам аргачлалын дагуу хөрөнгө оруулалтын <https://pimis.publicinvestment.gov.mn/> цахим системд төсөл арга хэмжээ бүрийн талаарх ерөнхий болон дэлгэрэнгүй мэдээлэл, санхүү эдийн засгийн шинжилгээг хийж холбогдох материалыг хавсаргасан боловч, зарим төсөл арга хэмжээг бүрэн үнэлээгүй, эрх бүхий байгууллагын газрын зөвшөөрөл, зураг төслийн магадлалын дүгнэлтийг хавсаргаагүй байна.

1.2.3. Эрх шилжин ирсэн 24 төсөл, арга хэмжээнээс шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 20 төсөл, арга хэмжээний дийлэнх нь буюу 13 нь Сүхбаатар аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд тусгагдаагүй байна. Үүнд: Тусгай зориулалтын байгууламж худалдан авах, объектын засвар үйлчилгээ, шугам сүлжээ байгуулах, Алтан овооны хамгаалалтын хашаа, цаг уурын байгууллагын засвар, Уулбаян, Баяндэлгэр сумдын 150 ортой цэцэрлэг, Сүхбаатар, Түвшинширээ сумдын 320 суудалтай сургуулийн барилга, ногоон байгууламж, ариутгалын пункт, өвлийн хүлэмж, дулааны шугам, цахилгаан хангамж зэрэг төсөл, арга хэмжээ багтаж байна. Өөрөөр хэлбэл, тухайн төсөл, арга хэмжээнүүд аймгаас санал хүргүүлээгүй боловч улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад орж батлагдсан байна.

1.3. Төсвийн тухай хуульд заасан хувь хэмжээнээс бага санхүүжих дүнтэй 2 төсөл арга хэмжээ, магадлалын ерөнхий дүгнэлтгүй 12 төсөл, арга хэмжээ, техникийн тодорхойлолтгүй 4 төсөл арга хэмжээг төлөвлөж, улсын төсөвт батлагдсан байна.

1.3.1. Сургуулийн барилга, 320 суудал /Сүхбаатар, Түвшинширээ сум/ 9,625.6 сая төгрөг, Цэцэрлэгийн барилга, 150 ор /Сүхбаатар, Уулбаян сум/ 3,473.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг 2024-2026 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн боловч санхүүжилтийг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулахгүйгээр багаар буюу батлагдсан төсөвт өртөгтэй харьцуулахад 2024 оны санхүүжилтийг 5-14 хувь буюу 500 сая төгрөгөөр баталсан нь эдгээр төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, төсөвт өртөг нэмэгдэх эрсдэлийг бий болгож байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр 29.3.5./шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах;/ заалттай нийцэхгүй байна.

1.3.2. Монгол улсын 2024 оны төсвийн тухай хууль 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан бөгөөд улсын төсөв батлагдахаас өмнө зураг төсөл, техникийн тодорхойлолт нь батлагдаагүй 16 төсөл, арга хэмжээ байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4./Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана./ дэх хэсэгтэй нийцэхгүй байна.

1.3.3. Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төслүүдийг төлөвлөснөөс үүдэн худалдан авах ажиллагааг эхлүүлэх, мөн тухайн ондоо хэрэгжүүлж дуусгах хугацаа алдсан 8

төсөл арга хэмжээ байна. Түүнчлэн, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг баталж, техникийн тодорхойлолт, зураг төсөл болон магадлалын дүгнэлт нь төсвийн жилийн дундуур эцэслэгдсэнтэй холбоотойгоор 13 төсөл нь улсын төсөвт батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглаж чадаагүй, 3 төсөл дутуу ашигласан бөгөөд нийт 16 төсөл, арга хэмжээ 15,325.7 сая төгрөгийн санхүүжилтийг ашиглаагүй байна.

1.3.4. Тоног төхөөрөмжийн 4 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг Улсын төсөв батлагдсаны дараа буюу 2024 оны 1-9 сард батлуулжээ. Улсын төсөв батлагдахаас өмнө тоног төхөөрөмжийн төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг бэлтгэх нь 1-рт төсөвлөлтийн шаардлагыг хангана, 2-рт тоног төхөөрөмжийн зах зээлийн үнийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, төсөвт өртгийг бодитой тодорхойлох боломжтой болно. “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3-т тоног төхөөрөмжийн төсөл арга хэмжээний төлөвлөлтөд тавигдах шаардлагыг зааж өгсөн боловч тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг тодорхойлох харилцаа зохицуулагдаагүй байна.

1.3.5. Тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт хожуу батлагдсан нь төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй, үнийн судалгааг хийх боломжгүй болгож, төсвийн үр ашгийг бууруулах эрсдэл дагуулж байна.

1.3.6. Сүхбаатар аймагт 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 22 төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн үе шатанд урсгал зардал, санхүүжих эх үүсвэр, төсөвт үзүүлэх нөлөөллийг Сангийн яамны “PIMIS” цахим системд оруулж, шаардлагатай маягтын дагуу боловсруулсан боловч хөрөнгө оруулалтын дараах ашиглалтын зардалтай холбоотой мэдээлэл, тухайлбал орон тоо, урсгал зардлын тооцооллыг зарим төсөл, арга хэмжээнд бүрэн тусгаагүй нь хэрэгжилтийн дараах урсгал зардлын дарамт, цаашдын төсөвт ирэх ачааллыг бодитой үнэлэх боломжийг хязгаарлаж байна. Үүнд:

- Цэцэрлэгийн барилга 150 ор / Сүхбаатар, Баяндэлгэр сум/
- Талын наран цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж /Сүхбаатар, Баруун-Урт сум/
- Уртын голын ногоон байгууламж /Сүхбаатар, Баруун-Урт сум/
- Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Сүхбаатар, Асгат сум/
- Хөдөөгийн алслагдсан багуудыг холбоожуулах 4G сүлжээ оруулах /Сүхбаатар, Баяндэлгэр, Уулбаян, Түвшинширээ, Халзан, Наран/

1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1 дэх заалттай нийцэхгүй 2 төсөл арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.

1.4.1. Талын наран цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж /Сүхбаатар, Баруун-Урт сум/ 400.0 сая, Уртын голын ногоон байгууламж /Сүхбаатар, Баруун-Урт сум/ 9,513.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг 2024 онд шинээр төлөвлөж хэрэгжүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.4 /Улсын төсвийн

хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: 13.4.1.орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт/ заалтыг зөрчин хориглосон арга хэмжээнүүдийг тусган төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

1.4.2. Сүхбаатар аймагт 2024 онд шинээр хэрэгжсэн 31 төсөл, арга хэмжээг төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 /“төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг/ заалтын дагуу тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих төсөл, арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

1.4.3. Магадлалын ерөнхий дүгнэлтгүй 12 төсөл, арга хэмжээ улсын төсөвт батлагдсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 /техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ/ дахь заалттай нийцэхгүй байна.

1.4.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон нийтийн эзэмшлийн талбай, ногоон байгууламжид хамаарах төсөл, арга хэмжээг улсын төсвөөр шинээр төлөвлөж хэрэгжүүлсэн нь хууль зөрчсөн төлөвлөлт болж, төсвийн зарцуулалтын үр ашиг, хариуцлагатай байдлыг алдагдуулж байна. Мөн магадлалын дүгнэлтгүй төсөл батлагдсан нь техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, газрын зөвшөөрөлгүй төслийг төсөвт тусгасан нь хэрэгжилтийн явцад зогсох, зардлын нэмэгдэл, үр ашиггүй хөрөнгө оруулалтын эрсдэл үүсгэх үр дагавартай байна.

БҮЛЭГ 2. АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД НЭГЖ ҮНЭЭР ИЛЭРХИЙЛСЭН ТӨСӨВТ ӨРТГИЙГ АШИГЛАХГҮЙ БАЙГАА НЬ ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙГ ШАЛГАРУУЛАХАД НӨЛӨӨЛСӨН БАЙНА.

2.1. Магадлалын дүгнэлтгүй төсөл, арга хэмжээг улсын төсөвт баталсан нь худалдан авах ажиллагаа хойшлох, хэрэгжилтэд хугацаа алдах эрсдэлтэй байна.

2.1.1. Сүхбаатар аймагт 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 13 төсөл, арга хэмжээнд огт санхүүжилт гараагүй бөгөөд үүнээс гэрээ цуцлагдсан 1, ажил зогссон 2, худалдан авах ажиллагаа хүчингүй болсон 3, зохион байгуулаагүй 1, гүйцэтгэгч шалгарсан ч ажил 2025 онд эхлэх 5, улсын комисс хүлээн аваагүй 1 байна. Эдгээрийн шалтгаанд дүн шинжилгээ хийхэд, магадлалын ерөнхий дүгнэлтгүй төслийг улсын төсөвт баталснаас зураг төсөл 2024 онд батлагдаж, худалдан авах ажиллагаа оройтож эхэлсэн нь гэрээ байгуулах хугацаа хойшлох, улмаар төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилт 2025 он руу шилжих нөхцөлийг бүрдүүлжээ.

2.1.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.13-т “Захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх” гэж заасны дагуу эрх шилжүүлсэн байна.

2.2. Тендерийн баримт бичигт алдангийн хувь хэмжээг оновчтой тусгаж, тендерийн төсөвт материал, тээвэр, машин ашиглалтын шууд зардлын төсвийг ажлын үе шат бүрээр тусгуулж, хяналтын төсвийг цахим системд байршуулах шаардлагатай байна.

2.2.1. Алдангийн хувь хэмжээг тендерийн баримт бичигт оновчтой, хэрэгжих боломжтой дүнгээр тусгаагүй нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, алдангийг арилжааны банкны бизнесийн зээлийн нэг хоногт ногдох дүнгээс ихгүйгээр тооцож, тусгаж өгөх шаардлагатай. Алдангийн дүнг зөв тодорхойлохгүй, ашиглахгүй байх нь гэрээний хугацаа удаа дараа сунгагдаж, төсөвт батлагдсан санхүүжилт бүрэн ашиглагдахгүй байхад хүргэж байна. Үүний улмаас тухайн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг дараа жилийн төсөвт шилжүүлснээр, шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдэд санхүүжилт олгох боломжийг алдаж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, ашиг тусыг иргэдэд хүргэх хугацаа хойшилж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Энэ нь төслийн үр ашгийг бууруулж, төсвийн хариуцлагатай зарцуулалтыг хангахгүй байгааг илтгэж байна.

2.2.2. Сангийн сайдын 2023 оны 12 сарын 25-ны өдрийн А/259 дугаар тушаалаар батлагдсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн /Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага/ бүлгийн зураг төсөл, загвар зураг хэсэгт “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтад ажлын зураг, өртгийн төсвийг хавсаргана. Ажлын зураг, өртгийн төсвийг тухайн салбарын дүрэм, журмыг үндэслэн боловсруулж холбогдох зардлын хувь хэмжээг нарийвчлан заасан байна.” гэж тодорхой тусгасан байна. Мөн өртгийн төсвийн талаар тус жишиг баримт бичгийн 21.2-т “Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.” гэж заасан нь захиалагч төсөвт өртгийг нэгж үнэ болон нийт үнээр гаргасан иж бүрэн хяналтын төсвийг тендер шалгаруулалтын баримт бичигт хавсаргахаар байна. Гэтэл Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/ төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын баримт бичигт зөвхөн ажлын тоо хэмжээг хавсаргасан бөгөөд хяналтын төсвийг цахим системд байршуулаагүй нь үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг худалдан авах ажиллагааны хууль, журам, зааварт заасны дагуу бэлтгээгүй болохыг харуулж байна.

2.2.3. Ажил гүйцэтгэх төсөл, арга хэмжээний материал, тээвэр, машин ашиглалтын шууд зардлын төсвийг ажлын үе шат бүрээр гаргаж ирүүлэх шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаагүй нь төсөл, арга хэмжээнд хяналт тавихад хүндрэл үүсгэж, гүйцэтгэлийн явцад захиалагч болон хяналтын байгууллагын шалгалтын үр нөлөөг бууруулж байна. Иймд цаашид ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын баримт бичигт материал, тээвэр, машин ашиглалтын шууд зардлын төсвийг ажлын үе шат бүрээр гаргаж ирүүлэх шаардлагыг тусгах нь шаардлагатай.

2.3. Тендерийн төсвийг нэгж үнээр гаргаж ирүүлэх шаардлагыг хангаагүй тендерт оролцогчдыг шалгаруулсан зөрчил нийтлэг байна.

2.2.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан төсөл, арга хэмжээнээс Сүхбаатар аймгийн Засаг даргад эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зохион байгуулсан ба 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа хүчингүй болж, газрын асуудал шийдэгдээгүйгээс 1 төсөл, арга хэмжээ буюу хөдөөгийн алслагдсан багуудын харилцаа холбооны дэд бүтэц төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.

2.3.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендерт оролцогч нар гомдол гаргах эрхтэй бөгөөд 2024 оны эрх шилжин ирсэн төсөл, арга хэмжээнүүдийн тендер шалгаруулалтын хувьд гомдол гаргаагүй байна.

2.3.3. Сангийн сайдын 2023 оны 12 сарын 25-ны өдрийн А/259 дугаар тушаалаар батлагдсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн 21.2-т заасан “Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.” гэсэн шаардлагыг хангаагүй тендерт оролцогчдыг шалгаруулсан зөрчил нийтлэг байна. Тухайлбал: Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/, Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Сүхбаатар, Асгат сум/, Сургуулийн барилга, 320 суудал /Сүхбаатар, Түвшинширээ сум/ зэрэг төсөл, арга хэмжээний тендерт шалгарсан компаниуд төсөвт өртгийг нэгж үнээр гаргаж ирүүлээгүй байна.

2.3.4. Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/ төсөл, арга хэмжээний 2022 оны 03 сарын 24-ний өдрийн 50/2022 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан 7,343,972,400 төгрөгийн төсөвт өртөгтэй трасс1-ийн хяналтын төсөвт замын ухмал, далангийн үе шатны ажлын хатуу материалыг зайлуулах /үндэслэл 25-07-12/ ажлын 3,326.13 м3 тохиромжгүй материалын тээврийн зардал 5 км газарт 13,280,066.29 төгрөгөөр тооцож батлагдсан. Гэвч Монгол зам групп ХХК-ийн тендерт шалгарсан төсөвт дээрх 3,326.13 м3 тохиромжгүй материалыг 560 км газарт 709,934,320.39 төгрөгөөр тээвэрлэхээр тусгаж, хучилтын үе шатны ажлын

өртгийн төсвийг хэт өндрөөр ирүүлснийг хянаагүй. Үнэлгээний хороо тендерийн төсөв дэх ухмал, далангийн үе шатны ажил хяналтын төсвөөс хэт их байхад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26.4.2-т заасан “санал болгосон бараа, ажил, үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцсэн байх” шаардлагыг хангаагүй тендерт оролцогчийг шалгаруулсан.

2.3.5. Тодруулбал, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26.4.2 дахь заалт болон “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн 21.2 дахь заалттай нийцээгүй буюу шаардлага хангаагүй тендерийн төсвийг ирүүлсэн Монгол зам групп ХХК-ийг үнэлгээний хороо шалгаруулсан нь санхүүжилтийг урьдчилж авах зөрчлийн суурь шалтгаан байна.

БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ БОДИТОЙ, ҮНЭН ЗӨВ БАТАЛГААЖУУЛААГҮЙН УЛМААС ГҮЙЦЭТГЭЛЭЭС ИЛҮҮ САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ЗӨРЧИЛ НИЙТЛЭГ БАЙНА.

3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн олгохгүй байна.

3.1.1. “Баруун-Урт-Сүхбаатар чиглэлийн хатуу хучилттай авто зам, 61.9 км, гүүр, 24 у/м /Сүхбаатар, Баруун-Урт, Сүхбаатар сум/” төсөл арга хэмжээний 2022 оны 03 сарын 24-ний өдрийн 50/2022 дугаартай магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан 7,343,972,400 төгрөгийн төсөвт өртөгтэй трасс1-ийн хяналтын төсөвт замын ухмал, далангийн ажлын үе шатны хатуу материалыг зайлуулах /үндэслэл 25-07-12/ ажлын 3,326.13 м3 тохиромжгүй материалын тээврийг 5 км газарт 13,280,066.29 төгрөгөөр гүйцэтгэхээр батлагдсан. Гэтэл тендерт шалгарсан Монгол зам групп ХХК-ийн төсөвт дээрх 3,326.13 м3 тохиромжгүй материалыг 560 км газарт 709,934,320.39 төгрөгөөр тээвэрлэхээр тусгаж, гэрээ байгуулж, мөн 709,934,320.39 төгрөгөөр тээвэрлэснээр шууд зардлын гүйцэтгэл гаргасан. Энэхүү тээврийн шууд зардлын дүн дээр “Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм ЗЗБНБД 81-013-2019”-ийн дагуу тооцсон 273,170,238.31 төгрөгийн зардал нэмэгдэж, нийт 983,104,558.70 төгрөг гүйцэтгэлд илүү тусгасан. Мөн гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээг хяналтын төсвийн нэгж өртгөөр тооцоход бодит гүйцэтгэл 4,032,264,698.36 төгрөг, олгосон санхүүжилт 4,847,563,331.00 төгрөг бөгөөд 815,298,632.64 төгрөгийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон.

3.1.2. “Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Сүхбаатар, Асгат сум/” төсөл арга хэмжээний тендерт шалгарсан төсөвт даланд тохирох материалыг 2 км-ээс, суурийн доод үеийн материалыг 5 км-ээс, ургамлын үе бүхий хөрсийг 1 км-т тээвэрлэхээр тусгасан нь магадлалаар баталгаажсан хяналтын төсөвт нийцэж байх боловч гэрээ байгуулах шатанд ажлын үндэслэл /шифр/, тээврийн тарифыг зассан гэх

шалтгаанаар тендерийн төсвийг өөрчилсөн, ингэхдээ гэрээний нийт дүнг өөрчлөөгүй боловч газар шорооны ажил болон хучилтын ажлын материалын тээврийн зайг үндэслэлгүйгээр нэмэгдүүлж, эдгээр үе шатны ажлын төсөвт өртгийг өсгөсөн байна. Тодруулбал даланд тохирох материал болон суурийн доод үеийн материалыг 15 км-ээс, ургамлын үе бүхий хөрсийг 5 км-т тээвэрлэнэ гэж төсвийг өөрчилж, энэхүү өөрчилсөн зай, км-ээр гүйцэтгэл гарган, 2024 оны 12 сарын 11-ний өдөр гүйцэтгэл №1-ийн 1,258,716,738 төгрөгийн санхүүжилтийг Алсын шар зам ХХК-д олгосон. Аудитын баг газар дээр нь очиж ажиллахад дээрх материалуудыг 2.3 км зайнд тээвэрлэсэн нь тогтоогдсон бөгөөд 442,897,547.08 төгрөгийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон.

3.1.3. “Уртын голын ногоон байгууламж /Сүхбаатар, Баруун-Урт сум/” төсөл арга хэмжээний гүйцэтгэл №2-т 806,248,097 төгрөгийн 58 ширхэг багц усалгааны системийг суурилуулсан гүйцэтгэл гаргаж, 881,999,973 төгрөгийн санхүүжилтийг 2024.12.25-ны өдөр Их Модун ХХК-д олгосон. Аудитаар бодит гүйцэтгэлийг шалгахад 37 багц усалгааны системийг талбай дээр авчирч, суурилуулсан байна. Суурилуулаагүй 21 багц усалгааны системийн 291,900,000 төгрөгийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон.

3.1.4. “Соёлын төвийн барилга /Сүхбаатар, Онгон сум, 5 дугаар баг/” төсөл арга хэмжээний хамар ханын суурь цутгах 32.17 м.куб ажил, бетон шугаман суурь цутгах 72.7 м.куб ажил, ус тусгаарлагч битум түрхлэг 400 м.кв ажил, довжоог төмөр бетон гишгүүрийн хамт цутгах 21.67 м.куб ажил болон бетон зуурмаг бэлтгэх 126.54 м.куб ажлууд хийгдээгүй, далд ажлын акт, фото зургаар баталгаажуулахгүй байхад гүйцэтгэлийг баталгаажуулан 2024.12.24-ний өдөр 318,269,493 төгрөгийн санхүүжилт олгосон. Дээрх хийгдээгүй ажлын тоо хэмжээгээр төсөвт өртгийг тооцоолоход 68,170,032.00 төгрөгийн илүү санхүүжилтийг Эс Жи Си ХХК-д олгосон зөрчил илэрсэн.

3.1.5. Дээрх нийт 1,618,266,211.72 төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5.1.2 “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 5.1.5. “хариуцлагатай байх”, 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1.6 “Хууль, журмын шаардлага хангасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийн эрхийг нээх, шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийг олгохгүй байх”, “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 3.16 “Барилгын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, чанаргүй, дутуу гүйцэтгэсэн, захиалагч болон эрх бүхий байгууллагын шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахгүй. Энэ тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон хөрөнгө оруулагч санхүүжилт олгохгүй байж болно.” дахь заалтыг тус тус зөрчсөн.

3.1.6. Дээрх 4 төсөл арга хэмжээний хувьд 2024 оны сүүлийн санхүүжилт олгосон өдрөөр тасалбар болгон магадлалаар баталгаажсан нэгж үнийн өртгийн төсөв, гэрээний нэгж үнийн өртгийн төсөв, ил, далд ажлын акт, фото зураг зэргийг үндэслэн гүйцэтгэлийг дахин бодитоор баталгаажуулж, гүйцэтгэгч компаниудад олгосон илүү санхүүжилтийг ашигласан хугацаанд нь ногдох хохирлыг тооцож, арилгуулах албан шаардлагыг Сүхбаатар аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүллээ.

3.1.7. “Мал эмнэлгийн хяналт, ариутгалын пунктын тоног төхөөрөмж худалдан авах /Сүхбаатар, Баруун-Урт сум/ төсөл арга хэмжээний шалны нэмэлт ажлын гүйцэтгэл дэх бетон шалны ажил гүйцэтгэсэн акт үйлдээгүй, фото зургаар баримтжуулаагүй, 100м.кв талбайн 20м.куб бетон цутгалтын /11-010-14/ ажлыг хийгээгүй 4,718,046.0 төгрөгийн зөрчлийг илрүүлсэн тул Буянт-Ас ХХК-д төлбөрийн акт тогтоосон.

3.1.8. Дулаан хангамжийн шугам сүлжээ, зуухны барилга /Сүхбаатар, Асгат сум/ төсөл, арга хэмжээний 2024 оны гүйцэтгэл дэх 72 м гадна дулааны шугам, сувгийн ажилд акт үйлдсэн боловч 55 м шугам сүлжээний гүйцэтгэлийг фото зургаар баримтжуулаагүй зөрчил илэрсэн тул захиалагчийн хяналт хэрэгжүүлэгчид албан шаардлага хүргүүллээ.

3.1.9. Эрх шилжиж ирээгүй дараах 3 төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон зөрчил илэрлээ. Үүнд:

- Ганга нуурын бохирдолт, ширгэлтээс хамгаалах, урсцыг сайжруулах төслийн 2 дугаар үе шат /Сүхбаатар/Дарьганга төсөл арга хэмжээний УБТ ГАРДЕН ХХК-тай байгуулсан 595,850,000 төгрөгийн гэрээний гүйцэтгэлд хийгдээгүй “Баянбулаг орчмын булгийн эх хамгаалах, мод тарих 67 сая төгрөгийн ажил, бусад зардал /шувуу харах цамхгийн хажууд сүүдрэвч сандал байрлуулах, мэдээллийн самбар байрлуулах 32 сая төгрөгийн ажил/” нийт 99,000,000 төгрөгийн ажлыг хийснээр гүйцэтгэл гарган санхүүжилт авсан.
- Сумын төвийн төвлөрсөн шугам сүлжээ /Сүхбаатар, Дарьганга сум/ төсөл, арга хэмжээний гадна дулаан хангамжийн хийгдээгүй ажлын гүйцэтгэл гаргаж, Одкон холдинг ХХК 291,070,446.76 төгрөгийн санхүүжилтийг илүү авсан.
- Сургуулийн барилга, 640 суудал /Сүхбаатар, Баруун-Урт сум, 3 дугаар сургууль/ төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд В, Д блокийн суурийн дам нуруу төмөр бетоноор цутгах ажил, бетон хамар ханын суурь цутгах ажлуудыг Стандарт холдинг ХХК хийснээр гүйцэтгэл гаргаж, санхүүжилт авсан.

3.1.10. Эрх шилжин ирээгүй 3 төсөл арга хэмжээний дээрх зөрчилтэй холбоотой асуудлаар Сүхбаатар аймгийн ГХБХБГ-т албан шаардлага өгч, мөн Үндэсний аудитын газрын хариуцсан аудитуудад зөрчлийн дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүллээ.

3.1.11. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй зарим төсөл, арга хэмжээнд баримтлах хууль, журам, норм, дүрмийн шаардлагыг зөрчиж, гүйцэтгэл хийгдээгүй ажлыг баталгаажуулах, үндэслэлгүйгээр тээврийн зайг хэтрүүлэн тооцох, магадлалын дүгнэлт, хяналтын төсөвт тусгагдаагүй өртөг, тоо хэмжээг гүйцэтгэлд тусган санхүүжилт олгосон нь Төсвийн тухай хуулийн үр ашиг, хэмнэлттэй байдлыг хангах зарчим алдагдах, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, зорилтот үр дүнд хүрэх санхүүгийн болон захиргааны чадамжийг бууруулах, улмаар төрд эдийн засгийн хохирол учруулах нөхцөл байдлыг бүрдүүлсэн байна.

3.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй 6 төсөл арга хэмжээний 8 гэрээний хугацаа сунгагдсан байна.

3.2.1. Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт 62,369.0 сая төгрөгийн санхүүжилттэй төсөл, арга хэмжээ батлагдсан ч зураг төсөл баталгаажаагүйгээс худалдан авах ажиллагаа хугацаандаа зарлагдаагүй, гүйцэтгэгч нар гэрээний нөхцөлийг зөрчиж, ажил, үйлчилгээний хуваарьт хугацааг мөрдөөгүй ч хариуцлага тооцоогүй зэрэг шалтгааны улмаас 15,325.7 сая төгрөгийн санхүүжилтийг ашиглаж чадаагүй бөгөөд уг үлдэгдлийг улсын төсөвт татуулсан. Үүний улмаас тухайн төсөл, арга хэмжээг дараа жилийн төсөвт дахин суулгах шаардлага үүсэж, шинэ хэрэгцээ шаардлагад нийцсэн бусад төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх санхүүгийн боломжийг алдах эрсдэлүүд үүсэж байна.

3.2.2. Төсвийн тухай хуульд тусгагдсан Сүхбаатар аймагт 2024 онд хэрэгжүүлж дуусгах 10 төсөл, арга хэмжээнээс 8 нь батлагдсан санхүүжилтээ бүрэн авч хэрэгжсэн, 2 төсөл, арга хэмжээ “Орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээний ажил”-ын хувьд улсын комисс хүлээн аваагүй, Ганга нуурын аялал жуулчлалын цогцолборын цахилгаан хангамжийн хувьд хэрэгжээгүй байна.

3.2.3. Сангийн сайдын 2023 оны 12 сарын 25-ны өдрийн А/259 дугаар тушаалаар батлагдсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн 4.1-д ажил гүйцэтгэх хугацааг сунгахыг дараах байдлаар зохицуулжээ. Үүнд: Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:

4.1.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;

4.1.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;

4.1.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;

4.1.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулан хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.

3.2.4. Гэрээний хугацаа сунгасан төсөл арга хэмжээнүүдийн хувьд хугацаа сунгасан шалтгаан болон холбогдох бусад мэдээллийг дараах хүснэгтээр дэлгэрэнгүй харууллаа.

Хүснэгт 1. Гэрээний хугацаа сунгасан төсөл арга хэмжээ

Төсөл, арга хэмжээний нэр		Гэрээний хугацаа	Сунгасан хугацаа	Хугацаа сунгасан шалтгаан	Комиссын актын огноо
Мал эмнэлгийн хяналт, ариутгалын пунктын тоног төхөөрөмж худалдан авах /Сүхбаатар, Баруун-Урт сум/	Багц 1	2024.07.19-2024.10.01	2024.10.01-2024.12.25	Үйлдвэрлэгч улсаас нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилчид ирж суурилуулах, ажиллуулах, туршилт тохиргоо хийх байсан боловч монголын виз хойшилсноос өөрийн инженерүүдээ Хятад улс руу явуулж зааварчилгаа авах	2024.12.24
	Багц 2	2024.07.19-2024.08.19	2024.08.19-2024.10.30	Барааны үйлдвэрлэлийн хугацаа удааширсан	2024.10.14
Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Сүхбаатар/		2024.06.04-2024.07.04	2024.07.04-2024.10.20	Улсын баяр наадмын амралттай холбоотойгоор хил гааль дээр барааны бөөгнөрөл үүсэж хүлээгдэж байгаатай холбоотойгоор	2024.08.06
Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /Сүхбаатар/		2020.07.28-2023.11.21	2024.04.15-2024.12.15	Цаг агаарын байдал, хятад улсаас оруулж ирэх бараа материал нь удааширсантай холбоотойгоор	2024.10.25
			2024.12.15-2024.12.30	Сүүлийн санхүүжилт авах хүсэлт үүсгэх, гүйцэтгэлийн баримт бичиг бүрдүүлэхэд хугацаа шаардагддаг гэх шалтгаанаар	
Талын наран цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж /Сүхбаатар, Баруун-Урт сум/	Багц 1	2024.05.08-2024.12.03	2024.12.03-2024.12.30	Гүйцэтгэлийн санхүүжилт авах хугацаа удааширсантай холбоотойгоор	2024.12.13
Соёл амралтын хүрээлэн /Сүхбаатар, Баруун-Урт сум/	Багц 1	2022.04.21-2024.07.01	2024.07.01-2025.10.01	Багц 2 гэрээт ажилтай уялдаж С1, С2, С3 болон А3 блокуудад нэмэлт ажлууд гарч, зурагт нэмэлт өөрчлөлт орсон, явган зам талбайн ажил гүйцэтгэх шалтгаанаар	-
	Багц 2	2023.05.23-2024.11.28	2024.11.28-2025.08.15	110 квт-ын ЦДАШ-ын шилжүүлэлт хийгдээгүй, нүүлгэн шилжүүлэх зардал тусгагдаагүй, мөн газар шорооны ажил нэмэлтээр гарсан зэрэг шалтгаанаар	-

Аймгийн төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2024.04.09-2024.10.18	2024.10.18-2025.08.01	Гүйцэтгэгч байгууллагын 2024.11.28-ны өдрийн 1/274 тоот гэрээ сунгах хүсэлт, тайлбарыг үндэслэн	-
--	-----------------------	-----------------------	---	---

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар

3.2.4. Дээрх төсөл, арга хэмжээнүүд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй, дээр дурдсан шалтгаануудын улмаас гэрээний хугацааг сунгасан байна. Шалтгаануудыг судалж үзэхэд гүйцэтгэл баталгаажуулахад хугацаа шаардлагатай гэх үндэслэлээр гэрээний хугацаа сунгах хүсэлт гаргасан нь гүйцэтгэгчийн буруу байх тул цаашид дээрх үндэслэлээр гэрээний хугацаа сунгалгүйгээр алданги тооцож байх шаардлагатай байна.

3.2.5. Спорт цогцолборын агаар сэлгэлтийн тоног төхөөрөмж /Сүхбаатар, Баруун-Урт сум/ төсөл, арга хэмжээний хувьд эрх шилжээгүй ба Биеийн тамир, спортын улсын хороотой 2024.03.01-ний өдрийн УТ2403100381 дугаартай гэрээ байгуулан хэрэгжүүлсэн ч төсөл, арга хэмжээний ангилал зөрүүтэй шалтгаанаар Сангийн яамнаас санхүүжилт олгоогүй байна.

3.3. Улсын комисс нь үүрэг даалгавар биелээгүй байхад акт, дүгнэлт үйлдэж авто зам, барилга байгууламжийг хүлээн авч байгаа нь чанарт сөргөөр нөлөөлж байна.

3.3.1. Мал эмнэлгийн хяналт, ариутгалын пунктын тоног төхөөрөмж худалдан авах /Сүхбаатар, Баруун-Урт сум/ төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын 2024 оны 03 сарын 18-ны өдрийн Хөрөнгө оруулалтын ажлыг багцлах тухай А170 дугаар захирамжаар 2 багцад хуваан, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Багц 1 мал эмнэлгийн хяналт, ариутгалын пунктын тоног төхөөрөмж суурилуулалт 237.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй тоног төхөөрөмжүүдийг гэрээний дагуу комисс ажиллан, хүлээн авсан байна.

3.3.2. Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн хүрээнд малын эм, био бэлдмэл хадгалах зориулалттай хөргөгч, бод малын эхо аппарат тус бүр 13 ширхгийг 161.2 сая төгрөгөөр нийлүүлэх гэрээ байгуулж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь техникийн тодорхойлолт заасан үзүүлэлттэй нийцсэн байна.

3.3.3. Ажил гүйцэтгүүлэх төсөл арга хэмжээний хувьд барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын комиссоор өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжээгүй байхад хүлээн авсан дараах төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 1. Улсын комиссоос өгсөн үүрэг даалгавар, түүний биелэлт

Төсөл, арга хэмжээний нэр	Өгсөн үүрэг даалгавар	Биелэлт
---------------------------	-----------------------	---------

Талын наран цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламж /Сүхбаатар, Баруун-Урт сум/	Ногоон байгууламжийн камерын үндсэн шилэн кабелийн шугамыг Сүлжээ компаниас гаргасан ажлын зургийн дагуу Цагдаагийн газраас салгаж шууд худагт холболт хийж, дангаар нь явуулах ажлыг зохион байгуулах	Ирэх оны 3-4 сард багтаан шилэн кабелийн шугамыг шинэчлэн солих ажил хийгдэнэ
Мал эмнэлгийн хяналт, ариутгалын пунктын тоног төхөөрөмж худалдан авах /Сүхбаатар, Баруун-Урт сум/	Дугуйн цэвэрлэгээг гадна хаалганы орох хаалганд хийх	Хавар дулаан цагт хийхээр тохиролцов
	Усны хаягдлыг трап руу ороход налуу болгох	Дотор талд зүсэлт хийж суваг гаргахаар болов
Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /Сүхбаатар/	Дээврийн усны хаялга хийх, гадна зам талбайн хагарлыг засах, ногоон байгууламж байгуулах	2025 оны 4-р сард багтаан хийх
Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /Сүхбаатар/	Гадна тохижилтын зүлэгжүүлэлтийн ажлуудыг дулааны улиралд нөхөж хийх.	Дулааны улиралд хийнэ.
Баруун-Урт сум 960 хүүхдийн сургуулийн барилга	Барилгын дээврийн болон гадаргуугийн ус зайлуулах асуудлыг өндөржилттэй уялдуулах, спорт заал, урлаг заалны дулаан алдагдлын шалтгааныг тодруулах, шаардлагатай арга хэмжээ авах, дээврийн ус тусгаарлалтыг стандартын дагуу хийх, гадна хананы дулаан алдагдлыг багасгах	Үүрэг даалгавар биелэлтийн хуудас бөглөгдөөгүй, урлаг болон спортын заалны дээврээс ус гоожсон.

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар

3.3.4. Өмнөх аудитаар дулаан алдагдал ихтэй, өвлийн улиралд дотоод орчны температурын шаардлага хангахгүй байгаа зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн боловч уг зөрчлүүд бүрэн арилгаагүй тул ашиглалтад хүлээн авсан хоёр барилгын дулаан алдагдлын шалтгааныг тодорхойлох зорилгоор 2025 оны хөрөнгө оруулалтын явцын аудитын хүрээнд, хүйтний улиралд Барилгын хяналтын улсын байцаагчтай хамтран ажиллаж, шалгалт хийх хүсэлтийг албан бичгээр хүргүүлсэн. Үүнд:

- Сургуулийн дотуур байрны барилга, 50 ор /Сүхбаатар, Наран сум/ дулаан алдагдал ихтэй, өвлийн хүйтэнд өрөөний температур 7-9 градус байдаг.
- Эрүүл мэндийн төвийн барилга, 17 ор /Сүхбаатар, Мөнххаан сум/ ар талын өрөөнүүдийн /нар тусдаггүй/ дотор температур өвлийн улиралд 9 градусаас дээш халдаггүй.

3.3.5. Барьцаа хөрөнгийн данснаас үлдэгдэл санхүүжилтийг олгосон Спорт цогцолборын барилга нь 2024 оны 7-р сард ашиглалтад орсон бөгөөд ашиглагч байгууллагаас “Өнгөрсөн өвөл халаалт хангалтгүй, узелийн тоноглол хангалтгүй, заалны халаах хэрэгсэл нормд хүрээгүй, 7-8 халаалтын паар халаагүй” тухай албан бичиг ирүүлсэн. Иймд хөрөнгө оруулалтын явцын аудитаар барилгын хяналтын улсын байцаагчтай хамтран ажиллаж, шалтгааныг тодорхойлно.

3.3.6. Аймгийн төвийн 4 дүгээр тойргийн хатуу хучилттай авто зам, 9.1 км /Сүхбаатар, Баруун-Урт сум/ төсөл, арга хэмжээг 2024.12.30-ны өдөр комисс хуралдаж үүрэг даалгаврууд өгсөн боловч тэр өдрөө акт, дүгнэлт үйлдэж ашиглалтад хүлээн авсан байна. Иймд үүрэг даалгаврын хэрэгжилт болон зураг төслийн дагуу гүйцэтгэсэн эсэхийг хөрөнгө оруулалтын завсрын аудитаар авто замын улсын байцаагчтай хамтран шалгана.

3.4. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас шийдвэр ирээгүй шалтгаанаар зарим төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байна.

3.4.1. Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс ашиглалтад хүлээн авсан 7 төсөл арга хэмжээнээс Мал эмнэлгийн хяналт, ариутгалын пунктын тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний 2-р багцаар худалдан авсан 41 нэр төрлийн тоног төхөөрөмжийг аймгийн Засаг даргын 2024 оны 10 сарын 23-ны өдрийн Хөрөнгө бүртгэж, эзэмшүүлэх тухай А/603 дугаар захирамжийн дагуу аймгийн Мал эмнэлгийн газрын данс бүртгэлд бүртгэсэн, бусад төсөл, арга хэмжээний хувьд ТӨБЗГ-аас шийдвэр ирээгүй тул данс бүртгэлд тусгаагүй байна.

3.4.2. Барьцаа хөрөнгөний данснаас үлдэгдэл санхүүжилтийг олгосон 3 төсөл арга хэмжээнээс 3-р сургуулийн барилгыг данс бүртгэлд тусгасан, /Спорт цогцолборын барилга, Түвшинширээ сумын сургуулийн дотуур байр/-ний хувьд ТӨБЗГ-аас шийдвэр ирээгүй тул данс бүртгэлд тусгаагүй байна.

3.4.3. Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд малын эм, био бэлдмэл хадгалах зориулалттай хөргөгч, бод малын эхо аппарат тус бүр 13 ширхэгийг худалдан авч, аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн А/474 дугаар захирамжаар бүх сумдын Засаг даргын Тамгын газрын данс бүртгэлд бүртгэн, эзэмшүүлэхээр шийдвэрлэсэн. Гэвч бод малын эхо аппаратыг ашиглах сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөсөн тул одоог хүртэл ашиглалтад ороогүй, сумдад тараагдаагүй, данс бүртгэлд бүрэн тусгагдаагүй байна.

3.4.4. Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээнээс 2 төсөл, арга хэмжээ /Мал эмнэлгийн хяналт, ариутгалын пунктын тоног төхөөрөмж худалдан авах, Үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтэц /-ний хувьд ашиглалтгүй байна.

---oOo---

Холбогдох байгууллагын санал:



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Сүхбаатар, Баруун-Урт, 7-р баг, Нутгийн удирдлагын
ордон

Утас: 70510111, Факс: 70510111

Цахим шуудан: admin@sukhbaatar.gov.mn

Цахим хуудас: Sukhbaatar.gov.mn

2025.05.13 № 01/496

танай 2025.05.07 -ны № 414 -т

「СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

「 Хариу тайлбар хүргүүлэх тухай 」

Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилтэнд хийсэн аудитын дүгнэлттэй танилцан дараах тайлбар саналыг хүргүүлж байна.

Уг аудитын дүгнэлтээр хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй холбоотой алдаа зөрчлүүд нилээд илэрсэн. Төлөвлөлтийн үйл явц, цахим систем хэрэгжиж эхэлснээр алдаа зөрчлүүд харьцангуй багасаж, үе шаттайгаар жил ирэх тутам сайжирч байна.

Шинэ тутам хөгжүүлж буй системд жил бүр шинэчлэлүүд хийгдэж байгаа ч хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үйл явцад гарч буй алдаа зөрчлүүд нэг мөсөн засч залруулагдахгүй, цаг хугацаа, тодорхой үе шатыг туулна.

Улсын төсөвт батлагдсан төсөл арга хэмжээг төсвийн жилд багтаан хэрхэн үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэх вэ гэсэн асуудал захиалагч нарт тулгардаг. Төсвийн ерөнхийлөн захирагч нараас эрх шилжүүлэн хэрэгжүүлж авсан төслүүдийн хувьд манай аймагт хэрэгжилт сайн, үр дүнтэй байгааг бодит байдал харуулна.

Эрх шилжин хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын ажлын явцад захиалагчийн хяналтыг барилга угсралтын ажил дээр аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, барилгын хөгжлийн төвтэй хамтран хэрэгжүүлж байна. Автозамын хувьд аймагт агентлаг байхгүй тул зохиогчийн хяналт болон техник технологийн хяналтын зөвлөх үйлчилгээ авсны үндсэн дээр хэрэгжүүлж байна.

Автозамын 2 төслийн хувьд магадлалаар орсон төсөв нь 2022 онд мөрдөгдөж байсан ЗТАЖуулчлалын сайдын 2007 оны 11-р сарын 20-ны өдрийн 186 тоот тушаалаар батлагдсан. Авто замын барилгын төсвийн жишиг норм БНБД81-25-07, Төмөрбетон гүүр, хоолойн барилгын төсвийн жишиг норм БНБД81-28-07-оор тооцогдож, Авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсөв бодох норм ЗЗБНБД 81-013-2019 дагуу төсвийн тооцоог боловсруулсан. Гэвч тус ажлыг 2024 онд тендер зарлаж гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулж ажиллуулах үед Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2023 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн А/141 дугаар тушаалаар батлагдсан ЗЗБНБД 83-25-2023, ЗЗБНБД83-26-2023, ЗЗБНБД 83-28-2023 суурь жишиг нормоор үнэлгээ хийх, Зам, тээврийн хөгжлийн сайдын

2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/63 дугаар тушаалаар Авто замын барилга, засвар, арчлалтын ажлын талбайд ажиллах ажилтнуудад үйлчлэх зардал"-ын хэмжээг нэмэгдсэн гэх мэт төсөв тооцооллох өөрчлөлтүүд орсон.

Мөн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем /PIMIS/ -ээр гүйцэтгэлийн нэгж дүнг шивж оруулахтай холбоотой 2022 онд ашиглаж байсан төсвийн норм, программ нь хоцрогдож нэгж үнэлгээ алдаа ихтэй гаргаж /үндсэн төсөвнөөс хол зөрүүтэй/ байсан тул шинэчлэгдсэн норм, төсвийн программ ашигласан. Ингэж өөрчлөхдөө гүйцэтгэгч компаниуд материалын зардлыг бууруулж, тээврийн зардлыг өсгөх замаар батлагдсан төсөвт өртөгт багтаан тохируулгууд хийсэн байна.

Монгол улсын хэмжээнд ажиллах хүчин, мэргэжилтэй ажиллах хүчний хомсдолд орсон энэ цаг үед төрийн алба болон хувийн хэвшилд ажиллаж байгаа боловсон хүчнээ тогтоон барин ажиллуулах асуудал хүндрэлтэй байгааг анхаарна уу.

Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлүүдийг арилгах, албан ажилдаа хэрэгжүүлж ажиллах бөгөөд гэрээний хэрэгжилт, хариуцлагыг сайжруулах чиглэлээр холбогдох албан тушаалнуудад үүрэг чиглэл өгөн ажиллана.



Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газар
Удирдлага
Сүхбаатар аймгийн Засаг дарга
Манлайбаатар Идэрбат
2025-05-13 16:44:32

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

“Улсын төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайлангийн төсөлд санал авахаар 2025.05.07-ны өдрийн 414 тоот албан бичгээр Сүхбаатар аймгийн Засаг даргад хүргүүлсэн бөгөөд 2025.05.13-ны өдрийн 01/496 тоот албан бичгээр хариу ирүүлсэн. Ирүүлсэн албан бичигт аудитын зарим дүн, дүгнэлттэй холбоотой тайлбар ирүүлсэн байх тул аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. “Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдаагүй 16 төсөл, арга хэмжээ, Сүхбаатар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн саналгүй 13 төсөл арга хэмжээ улсын төсөвт батлагдсан нь төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт уялдаагүй байгааг харуулж байна.
2. Магадлалын ерөнхий дүгнэлтгүй, техникийн тодорхойлолтгүй төсөл арга хэмжээнүүд улсын төсөвт батлагдаж байгаа нь худалдан авах ажиллагаа оройтох, улмаар батлагдсан санхүүжилтийг бүрэн ашиглахгүй байх сөрөг үр дагавартай байна.
3. Ажил гүйцэтгэх төсөл арга хэмжээний материал, тээвэр, машин ашиглалтын шууд зардлын төсвийг ажлын үе шат бүрээр гаргаж ирүүлэх шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж өгдөггүй нь төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлд тавих шат шатны хяналтын үр нөлөөг бууруулахаар байна.
4. Тендерийн төсвийг нэгж үнээр гаргаж ирүүлээгүй, үнэлгээний хороо хяналтын төсвийн нэгж үнэтэй нийцсэн эсэхийг үнэлдэггүйн улмаас ажил гүйцэтгүүлэх төсөл арга хэмжээний эхний үе шатны ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгох сөрөг үр дагаврыг бий болгож байна.
5. Захиалагч болон захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэгч нар ажил гүйцэтгүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж, бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгож байна.
6. Тендерийн баримт бичигт алдангийн хувь хэмжээг оновчтой тусгаагүйн улмаас төлөвлөсөн хугацаанд гүйцэтгээгүй компаниудад алданги ногдуулдаггүй, гэрээний хугацаа удаа дараа сунгагдах, оны эцэст хүйтний улиралд ашиглалтад хүлээлгэн өгөх, батлагдсан санхүүжилтийг бүрэн гүйцэд ашиглахгүй байх зэрэг сөрөг үр дагавартай байна.
7. Улсын комисс нь үүрэг даалгавар биелээгүй байхад акт, дүгнэлт үйлдэж авто зам, барилга байгууламжийг хүлээн авч байгаа нь авто зам, барилгын чанарт сөргөөр нөлөөлж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-т:

1. Улсын төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн ашиглахын тулд цаашид магадлалын ерөнхий дүгнэлттэй, техникийн тодорхойлолт батлагдсан төсөл арга хэмжээнүүдийг төлөвлөж, батлуулах.
2. Тендерийн баримт бичгийг батлах үе шатанд алдангийн хувь хэмжээг оновчтой буюу хэрэгжүүлэх боломжтой хэмжээгээр тусгасан эсэхэд хяналт тавьж ажиллах.
3. Ажил гүйцэтгэх хуваарийн дагуу захиалагчийн хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэн, тендерийн жишиг баримт бичигт заасан үндэслэлүүдээс бусад тохиолдолд гэрээний хугацааг сунгалгүйгээр алданги тооцож, гүйцэтгэгч компаниудыг хариуцлагажуулж, үүрэг даалгавар биелэх боломжгүй цаг хугацаанд барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авахгүй байх.
4. Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын баримт бичигт материал, тээвэр, машин ашиглалтын шууд зардлын төсвийг ажлын үе шатаар гаргаж ирүүлэх шаардлагыг тендерийн баримт бичигт тусгасан эсэхэд хяналт тавьж, төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн техник хяналт болон дотоод хяналтыг сайжруулах.

Сүхбаатар аймгийн Худалдан авах ажиллагааны газарт:

1. Тендерийн төсвийг нэгж болон нийт үнээр гаргаж ирүүлээгүй оролцогч нарыг үнэлгээний хороо шалгаруулахгүй байх, мөн нэгж үнээр бэлтгэж ирүүлсэн төсвийг магадлалаар баталгаажсан нэгж үнийн төсөвтэй нийцсэн эсэхийг үнэлж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26.4.2 дахь заалтыг мөрдөж ажиллах.

Үндэсний аудитын газарт хүргүүлж буй санал:

1. “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3-т тоног төхөөрөмжийн төсөл арга хэмжээний төлөвлөлтөд тавигдах шаардлагыг зааж өгсөн боловч тоног төхөөрөмжийн төсөвт өртгийг хэрхэн үндэслэлтэй, бодитой тодорхойлох талаар оновчтой зохицуулалтгүй байна. Иймд тус журмын 3.2.3-т дараах заалтыг нэмж тусгуулах саналтай байна. Тодруулбал: *“Тоног төхөөрөмжийн батлагдсан техникийн тодорхойлолтыг үндэслэсэн зах зээлийн үнийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, тухайн байгууллагын дүгнэлт, тайланд үндэслэн төсөвт өртгийг бодитой тодорхойлсон байх.”* гэсэн заалтыг нэмж тусгуулах талаар холбогдох эрх бүхий байгууллагуудад зөвлөмж хүргүүлэх саналтай байна.

---oOo---



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГЭРЭЭНИЙ ХУГАЦААГ ҮНДЭСЛЭЛГҮЙГЭЭР СУНГАЖ, ЗАРИМ ТӨСӨЛ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛЭЭС ИЛҮҮ
ОЛГОСОН БАЙНА.

АУДИТЫН НЭР: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: СБА-2025/06-16-ШТА-ГА

Баруун-Урт 2025 он



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Н.Болдбаатар

Утас: 70512127 Цахим хаяг: oyunboldg@audit.gov.mn

Аудитор Э.Алтансүх

Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Аудитор Б.Ганцэцэг

Утас: 70512127 Цахим хаяг: gantsetsegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
БҮЛЭГ 1. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА.	5
1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулж баталсан байна.....	5
1.3. Тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээний төсөвт өртгийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгосны үндсэн дээр орон нутгийн төсөвт тусгуулах шаардлагатай байна.	6
1.4. Хувийн өмчид шилжих 3 төсөл арга хэмжээг төлөвлөж, баталсан нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.2, төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх заалттай нийцэхгүй байна.....	7
БҮЛЭГ 2. АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД НЭГЖ ҮНЭЭР ИЛЭРХИЙЛСЭН ТӨСӨВТ ӨРТГИЙГ АШИГЛАХГҮЙ БАЙНА.	8
2.1. Худалдан авах ажиллагааны журмыг хуульд заасны дагуу сонгон хэрэгжүүлсэн байна.	8
2.2. Тендерийн баримт бичигт алдангийн хувь хэмжээг оновчтой тусгаж, тендерийн төсөвт материал, тээвэр, машин ашиглалтын шууд зардлын төсвийг ажлын үе шат бүрээр тусгуулж, хяналтын төсвийг нэгж үнэ болон нийт үнээр бэлтгэн цахим системд байршуулах шаардлагатай байна.	8
2.3. Тендерийн төсвийг нэгж үнээр гаргаж ирүүлэх шаардлагыг хангасан эсэхийг үнэлгээний хороо хянахгүй байгаа нь үе шатны ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү, дутуу олгох эрсдэлийг дагуулж байна.	9
БҮЛЭГ 3. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ БОДИТОЙ, ҮНЭН ЗӨВ БАТАЛГААЖУУЛААГҮЙ БАЙНА.	10
3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн олгохгүй байна.....	10
3.2. Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг сунгахгүй байх, гэрээнд заасны дагуу алданги тооцож хэвших шаардлагатай байна.	12
3.3. Зарим барилга, их засварт чанарын доголдол илэрсэн нь захиалагчийн техник хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байгаа бөгөөд урсгал засварын зардал нэмэгдэх, ашиглалтын хугацаа богиносгох зэрэг сөрөг үр дагавар үүсгэж байна.	13
3.4. Данс бүртгэлд тусгаагүй зарим төсөл, арга хэмжээнүүдийг бүртгэх талаар зөвлөмжийг санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн байна.	14
Холбогдох байгууллагын санал:	16
Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:.....	17
ДҮГНЭЛТ: 17	
ЗӨВЛӨМЖ: 17	

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
УИХ	Улсын Их хурал
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Төсөл арга хэмжээний эх үүсвэр	5
Хүснэгт 2	Гэрээний хугацаа сунгасан төсөл арга хэмжээ	12
Хүснэгт 3	Ашиглалтад хүлээн авсан зарим барилга, их засварын ажлын чанар байдал	14

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
Аудит үндэслэл, эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалтыг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн гүйцэтгэв.
Аудитын зорилт	Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд нийцлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг АИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг 2024 онд хэрэгжүүлсэн аймгийн Засаг дарга болон түүний харьяа байгууллагууд, захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэгч байгууллага болон зураг төслийн компаниуд, холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ түүний хэрэгжилт, баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагуудаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, судалгаа явуулах арга зүйг ашиглаж аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Н.Болдбаатар, аудитор Э.Алтансүх, Б.Ганцэцэг нар 2025 оны 04 сарын 01-ны өдрөөс 5 сарын 23-ны өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА.

1.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөтэй уялдуулж баталсан байна.

1.1.1. Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 07 дугаар тогтоолоор, мөн Сүхбаатар сумын ИТХ-ын А/10 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр нийт 82 төсөл, арга хэмжээнд 28,654.78 сая төгрөг батлагдсан байна. Үүнийг санхүүжилтийн ангилал, төсөл арга хэмжээний тоо, өртгөөр хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. Төсөл арга хэмжээний эх үүсвэр

Санхүүжилтийн төрөл	Төсөл, арга хэмжээний тоо	Төсөвт өртөг (сая.₮)
1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын сан	17	8,300.18
2. Замын сан	8	3,070.80
3. Их засварын зардал	13	6,666.84
4. Байгаль хамгаалах, нөхөн сэргээлтийн зардал	14	412.67
5. ЭМ, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэгийн сан	30	10,204.30
Нийт дүн	82	28,654.78

Эх сурвалж: Аймаг, сумын ИТХ-ын тогтоол

1.1.2. Сүхбаатар аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээнд нийт 82 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсанаас шинээр хэрэгжих 55, өмнөх оноос шилжсэн 27 төсөл, арга хэмжээ байна.

1.1.3. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 03 дугаар тогтоолоор үндэсний үнэт зүйл, хүний хөгжил, амьдралын чанар ба дундаж давхарга, эдийн засаг, засаглал, ногоон хөгжил, амар тайван аюулгүй нийгэм, бүс орон нутгийн хөгжил гэсэн 8 зорилгын хүрээнд 137 зорилт дэвшүүлсэн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн төлөвлөсөн байна.

1.1.4. Тухайлбал: Суралцагчдад ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх, сургууль, цэцэрлэг, дотуур байрын хангамжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын засвар үйлчилгээг сайжруулах, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, төрийн байгууллагын ажиллах нөхцөл, техник, технологийг сайжруулах, төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, доройтсон талбайг нөхөн сэргээх, ховордсон биологийн төрөл зүйлийн нөөцийг хамгаалж, сэргээн нутагшуулах, бэлчээрийн

менежментийг сайжруулах гэх мэт төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

1.1.5. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулах, хүний хөгжил, эдийн засаг, засаглал, байгаль орчин, ногоон хөгжил, бүс, орон нутгийн хөгжил гэсэн 6 багц асуудлын хүрээнд 121 зорилт дэвшүүлж, 446 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцүүлэн төлөвлөсөн байна.

1.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг цахим системээр төлөвлөх ажил жигдрээгүй байна.

1.2.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

- 1.6. /Энэ журмын 1.5-д зааснаас бусад төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг Төсвийн тухай хуулийн 29¹.4-т заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (цаашид “цахим систем” гэх)-ээр хэрэгжүүлнэ;/
- 2.3.2.1. /орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнах;/

1.2.2. Хөрөнгө оруулалтын цахим системд бүртгэх, үнэлэх, эрэмбэлэх ажиллагаа жигдрээгүй нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эдийн засаг, нийгмийн үр өгөөжтэйгөөр төлөвлөх боломжийг хязгаарлах, ач холбогдол багатай төслүүдийг хэрэгжүүлэх эрсдэлийг үүсгэх үр дагавартай байна.

1.3. Тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээний төсөвт өртгийг мэргэжлийн байгууллагаар тогтоолгосны үндсэн дээр орон нутгийн төсөвт тусгуулах шаардлагатай байна.

1.3.1. Тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг орон нутгийн төсөв батлагдсаны дараа буюу тендер шалгаруулалт зохион байгуулахын өмнө боловсруулж, баталж байна. Орон нутаг төсөв батлагдахаас өмнө тоног төхөөрөмж худалдан авах төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг бэлтгэх нь 1-рт төсөвлөлтийн шаардлагыг хангана, 2-рт

мэргэжлийн байгууллагаар хийлгэх тул тоног төхөөрөмжийн төсөвт өртөг бодитой тодорхойлогдох ач холбогдолтой байна.

1.3.2. Иймд цаашид орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолтыг төсвийн төслийг боловсруулах шатанд боловсруулж, уг тодорхойлолтын дагуу мэргэжлийн байгууллагаар төсөвт өртгийг тогтоолгон орон нутгийн төсөвт тусгаж байх нь төсөвлөлтийн бодитой байдал, үндэслэл, үр ашгийг хангахад шаардлагатай байна.

1.3.3. Сүхбаатар сумын “Боловсрол, соёл, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр 2024 онд батлагдсан 3,350.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй, 10,204.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 30 төсөл, арга хэмжээнээс 182.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл арга хэмжээ нь урсгал зардлын шинж чанартай буюу хөрөнгө оруулалтын тодорхойлолт, шаардлагад нийцээгүй байна.

1.3.4. Тухайлбал: Олон нийтийг хамарсан уралдаан зохион байгуулах, улс, бүсэд амжилт гаргасан багш сурагчдыг урамшуулах, цэцэрлэг, сургуулийн багш нарыг магистрын сургалтад хамруулах, орон нутагт шаардлагатай нарийн мэргэжлийн эмч урьж ажиллуулах, ЕБС-д математикийн зөвлөх багш ажиллуулна, бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх, мэдээллээр хангах, сургалтын төлбөр /ЕБС/, англи хэлний зөвлөх багш, цахим хичээл, видео постер бэлтгэх сургалт, ЭМТ-өөс багуудад гэр сувилал ажиллуулах, эрүүл мэнд, боловсролын байгууллагын албан хаагчдын нийгмийн асуудлыг сайжруулах орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлэх зэрэг хөрөнгө оруулалтын шинжгүй төсөл арга хэмжээнүүдийг хөрөнгийн зардлаар төлөвлөж баталсан байна. Иймд цаашид төсөвт тусгах төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль болон төсвийн төлөвлөлтийн удирдамжид нийцүүлэн ангилах, урсгал шинжтэй зардлыг хөрөнгө оруулалтын зардлаас тусгаарлан тусгайлан баталж, төлөвлөх зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна. Энэхүү зохицуулалт нь төсвийн зарцуулалтын ил тод байдал, зориулалтын ашиглалт, ангиллын бодлогын уялдааг хангах, үр ашиггүй зардлыг бууруулах нөхцөл бүрдүүлэх ач холбогдолтой юм.

1.3.5. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 2024 онд 14 төсөл арга хэмжээг 412.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Тус байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал нь орон нутгийн төсөвт урсгал зардлаар батлагдсан боловч дээрх 14 арга хэмжээнд 243.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нөхөн сэргээх 3 арга хэмжээ тусгагдсан байна. Эдгээр нөхөн сэргээх арга хэмжээний хувьд биологийн болон техникийн нөхөн сэргээлт хийгдэх бөгөөд газар шорооны ажлын тоо хэмжээ ихтэй, захиалагчийн хяналт хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсэхээр байна.

1.4. Хувийн өмчид шилжих 3 төсөл арга хэмжээг төлөвлөж, баталсан нь төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.2, төсвийн тухай хуулийн 4.1.24 дэх заалттай нийцэхгүй байна.

1.4.1. Сүхбаатар аймагт 2024 онд шинээр хэрэгжсэн 55 төсөл, арга хэмжээнээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2./хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;/ дахь заалтад нийцээгүй “Гэр худалдан авах”, “Гэр дулаалга төсөл”, “Гэр хорооллын өрхүүдэд халаалт, дулаан, агаар сэлгэлтийн Чип багц нийлүүлэх” зэрэг төсөл арга хэмжээнүүд байна.

1.4.2. Дээрх төсөл арга хэмжээнүүд тухайн шатны төсвийн байгууллагын өмчлөлд шилжихгүй буюу айл, өрхийн өмчлөлд шилжиж байгаа нь мөн Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 /“төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг/ заалттай нийцээгүй байна.

БҮЛЭГ 2. АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТАД НЭГЖ ҮНЭЭР ИЛЭРХИЙЛСЭН ТӨСӨВТ ӨРТГИЙГ АШИГЛАХГҮЙ БАЙНА.

2.1. Худалдан авах ажиллагааны журмыг хуульд заасны дагуу сонгон хэрэгжүүлсэн байна.

2.1.1. Орон нутгийн төсвөөр шинээр хэрэгжих 7,531.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 307.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 293.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл, арга хэмжээний хувьд шууд худалдан авалтын гэрээ байгуулж, хэрэгжүүлсэн байна. Эдгээр төсөл арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулахдаа худалдан авах ажиллагааны журмыг хуульд заасны дагуу сонгон, хэрэгжүүлсэн байна.

2.2. Тендерийн баримт бичигт алдангийн хувь хэмжээг оновчтой тусгаж, тендерийн төсөвт материал, тээвэр, машин ашиглалтын шууд зардлын төсвийг ажлын үе шат бүрээр тусгуулж, хяналтын төсвийг нэгж үнэ болон нийт үнээр бэлтгэн цахим системд байршуулах шаардлагатай байна.

2.2.1. Алдангийн хувь хэмжээг тендерийн баримт бичигт оновчтой, хэрэгжих боломжтой дүнгээр тусгаагүй нь төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, алдангийг арилжааны банкны бизнесийн зээлийн нэг хоногт ногдох дүнгээс ихгүйгээр тооцож, тусгаж өгөх шаардлагатай. Алдангийн дүнг зөв тодорхойлохгүй, ашиглахгүй байх нь гэрээний хугацаа удаа дараа сунгагдаж, төсөвт батлагдсан санхүүжилт бүрэн ашиглагдахгүй байхад хүргэж байна. Үүний улмаас тухайн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг дараа жилийн төсөвт шилжүүлснээр, шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдэд санхүүжилт олгох боломжийг алдаж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн, ашиг тусыг иргэдэд хүргэх хугацаа хойшилж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд сөргөөр

нөлөөлж байна. Энэ нь төслийн үр ашгийг бууруулж, төсвийн хариуцлагатай зарцуулалтыг хангахгүй байгааг илтгэж байна.

2.2.2. Сангийн сайдын 2023 оны 12 сарын 25-ны өдрийн А/259 дугаар тушаалаар батлагдсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн /Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага/ бүлгийн зураг төсөл, загвар зураг хэсэгт “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтад ажлын зураг, өртгийн төсвийг хавсаргана. Ажлын зураг, өртгийн төсвийг тухайн салбарын дүрэм, журмыг үндэслэн боловсруулж холбогдох зардлын хувь хэмжээг нарийвчлан заасан байна.” гэж тодорхой тусгасан байна. Мөн өртгийн төсвийн талаар тус жишиг баримт бичгийн 21.2-т “Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.” гэж заасан нь захиалагч төсөвт өртгийг нэгж үнэ болон нийт үнээр гаргасан иж бүрэн хяналтын төсвийг тендер шалгаруулалтын баримт бичигт хавсаргахаар байна.

2.2.3. Гэтэл “Дулааны станцын 1 болон 2-р зуухны засвар шинэчлэлт” төсөл арга хэмжээний хяналтын төсвийг нэгж үнийн төсөвгүйгээр, зөвхөн нийт үнийн төсвийг худалдан авах ажиллагааны цахим системд байршуулсан, “Сургуулийн их засвар /Асгат сум/”, “Боловсрол хорооллын хойд хэсгийн авто зам” төсөл арга хэмжээнүүдийн хяналтын төсвийг байршуулаагүй, зөвхөн магадлалын дүгнэлт, ажлын тоо хэмжээг байршуулсан нь үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг худалдан авах ажиллагааны хууль, журам, зааварт заасны дагуу бэлтгээгүй болохыг харуулж байна.

2.2.4. Ажил гүйцэтгэх төсөл, арга хэмжээний материал, тээвэр, машин ашиглалтын шууд зардлын төсвийг ажлын үе шат бүрээр гаргаж ирүүлэх шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаагүй нь төсөл, арга хэмжээнд хяналт тавихад хүндрэл үүсгэж, гүйцэтгэлийн явцад захиалагч болон хяналтын байгууллагын шалгалтын үр нөлөөг бууруулж байна. Иймд цаашид ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын баримт бичигт материал, тээвэр, машин ашиглалтын шууд зардлын төсвийг ажлын үе шат бүрээр гаргаж ирүүлэх шаардлагыг тусгах нь шаардлагатай.

2.3. Тендерийн төсвийг нэгж үнээр гаргаж ирүүлэх шаардлагыг хангасан эсэхийг үнэлгээний хороо хянахгүй байгаа нь үе шатны ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү, дутуу олгох эрсдэлийг дагуулж байна.

2.3.1. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан төсөл, арга хэмжээнээс тайланд онд шинээр хэрэгжих 12 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100 хувь цахимаар зохион байгуулсан байна.

2.3.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендерт оролцогч нар гомдол гаргах эрхтэй бөгөөд Гэр хорооллын өрхүүдэд халаалт, дулаан, агаар сэлгэлтийн Чип багц

нийлүүлэх /Баруун-Урт сум/ төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцсон “Өнө монгол гэр” ХХК гомдол гаргасан байна. Тус гомдлын дагуу захиалагчаас ирүүлсэн баримт материалд үндэслэн Сангийн яам хянаж үзээд шаардлагад нийцээгүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна гэсэн хариуг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн “Гомдол хянасан тухай” 03/5321 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн байна.

2.3.3. Сангийн сайдын 2023 оны 12 сарын 25-ны өдрийн А/259 дугаар тушаалаар батлагдсан “Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг”-ийн 21.2-т заасан “Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.” гэсэн шаардлагыг үнэлгээний хороо тендерийг хянан үзэх үе шатанд анхаарч үздэггүй байна. Өөрөөр хэлбэл хяналтын төсвийн төсөвт өртгийг нэгж болон нийт үнээр бэлтгэж, худалдан авах ажиллагааны цахим системд байршуулдаггүй, мөн тендерт оролцогч нар нэгж үнээр бэлтгэсэн төсөв ирүүлсэн эсэхийг шалгуур болгодоггүй байна. Энэ нь ажил гүйцэтгүүлэх төсөл арга хэмжээний үе шатны ажлын төсөвт өртөг нь бодит гүйцэтгэлээс зөрүүтэй болох, улмаар явцын санхүүжилтийг илүү, дутуу олгох эрсдэлийг бий болгохоор байна.

БҮЛЭГ 3. ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ БОДИТОЙ, ҮНЭН ЗӨВ БАТАЛГААЖУУЛААГҮЙ БАЙНА.

3.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын бодит гүйцэтгэлд үндэслэн олгохгүй байна.

3.1.1. ОНТХО, ОНХС-ийн үйл ажиллагаанд 2024 онд хийсэн аудитаар “Зөөврийн наадмын талбай - Дарьганга сум” төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг шалгасан бөгөөд хээрийн үзвэрийн асартай холбоотой асуудлыг үргэлжүүлэн шалгах шаардлага үүсч, дараагийн аудитаар нарийвчлан шалгахаар хойшлуулсан. Тодруулбал тухайн төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт болон нийлүүлэгч компанийн ирүүлсэн үнийн саналаас үзэхэд хээрийн үзвэрийн асрыг 2 ширхэгийг /1 ширхэг нь 76,950.0 мянган төгрөг / нийлүүлэгдэхээр байхад 1 ширхэг дутуу нийлүүлэгдсэн байна.

3.1.2. “Боловсрол хорооллын хойд хэсгийн авто зам” төсөл арга хэмжээний хувьд замын хашлага байрлуулах ажлыг хийгээгүй байхад хийснээр гүйцэтгэлийг баталгаажуулж, бодит гүйцэтгэлээс 50.7 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон байна.



3.1.3. Сүхбаатар сумын “Шинэ цэцэрлэг барих” төсөл, арга хэмжээний хувьд суурийн ажлын хамар ханын бетон шугаман суурь цутгах 23.13 м.куб ажил, бетон зуурмаг бэлтгэх 23.13 м.куб ажил, рамьн ажлын дам нуруу цутгах 168.69 м.куб ажил, төмөр бетон багана цутгах, арматурчлах 40.75 м.куб ажлууд хийгдээгүй байхад хийснээр гүйцэтгэл гаргасныг захиалагч, захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч баталгаажуулж, санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгосон байна.



3.1.4. Сумдын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах /10 сум/ төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлэгдсэн Nissan patrol Y61 автомашины нэг бүрийн үнэ зах зээлийн үнээс өндөр байгаа талаар 2024 онд хийсэн аудитаар захиалагчаас ирүүлсэн 2024.06.17-ны өдрийн 01/760 тоот албан бичигт дараах тайлбарууд ирүүлсэн нь үндэслэлгүй байна. Үүнд:

- 8 удаагийн үйлчилгээ /хөдөлгүүрийн тос, тосны шүүр, салоны агаар шүүгч/-ний хөлс 1 автомашинд 4.0 сая төгрөг, нийт 40.0 сая төгрөгийг зах зээлийн үнэ дээр нэмж тооцсон гэх боловч Моннис моторс ХХК нь шинэ автомашинд 4 удаагийн үйлчилгээний эрх үнэ төлбөргүй олгодог байна. Иймд 8 удаагийн үйлчилгээний 40.0 сая төгрөгийн хөлс нэмж тооцсон гэх тайлбар нь үндэслэлгүй байна.

- Тээврийн зардлын өсөлт /зөрүү/ 1 автомашинд 6.0 сая төгрөг, нийт 60.0 сая төгрөгийг зах зээлийн үнэ дээр нэмж тооцсон гэх тайлбар ирүүлсэн. Энэхүү тайлбараас үзэхэд захиалагч тээврийн зардал өсөж магадгүй гэж нэмэгдэл зардлыг төсөвт өртөгт тусгаж тендер зарласан гэж ойлгогдохоор байх тул дээрх тайлбар нь үндэслэлгүй байна.

3.1.4. Иймд дээрх 4 төсөл арга хэмжээтэй холбоотой асуудлаар захиалагч болон гүйцэтгэгч компаниудаас дахин тайлбар, тодруулга авах ажиллагаа хийгдэх бөгөөд хөрөнгө оруулалтын явцын аудитаар эдгээр асуудлыг эцэслэн шийдвэрлэнэ.

3.2. Тендерийн баримт бичигт зааснаас бусад тохиолдолд төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг сунгахгүй байх, гэрээнд заасны дагуу алданги тооцож хэвших шаардлагатай байна.

3.2.1. Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан 82 төсөл, арга хэмжээнээс 11,779.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 50 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж дууссан, 11,531.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй 10 төсөл, арга хэмжээний хэрэгжилт дутуу, 2,920.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

3.2.2. Тендерийн баримт бичигт заасан хугацаа сунгах хүсэлт гаргах тохиолдлуудаас бусад шалтгаанаар хүсэлт гаргаж, хугацаа сунгах зөрчил нийтлэг байна. Тухайлбал зарим төсөл арга хэмжээний хугацаа сунгасан шалтгааныг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 2. Гэрээний хугацаа сунгасан төсөл арга хэмжээ

Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний хугацаа	Сунгасан хугацаа	Хугацаа сунгасан шалтгаан
Гэр хорооллын өрхүүдэд дулаан, сэлгэлтийн Чип багц нийлүүлэх /Баруун-Урт сум/	2024.07.09-2024.11.15	2024.11.15-2025.09.15	Хурлын тэмдэглэл Чип/02: Иргэдээс татан төвлөрүүлэх 534.4 сая төгрөг дутуугаас дараагийн шатны нийлүүлэлтээ хийхэд хүндрэлтэй байна
Автоклав авах /МЭГ/ худалдан	2024.07.24-2024.08.24	2024.08.24-2024.12.25	Аппаратыг үйлдвэрлэх үйлдвэрлэлийн явц удаашралтай, төлөвлөсөн хугацаанд үйлдвэрлэх боломжгүй гэж үйлдвэрээс мэдэгдсэн.
Дулааны станцын 1 болон 2-р зуухны засвар шинэчлэлт	2024.08.15-2024.10.22	2024.10.22-2025.11.15	Тусгай хийц хэлбэртэй тоосго үйлдвэрлэж нийлүүлэх шаардлага гарсан, хил гааль, тээвэрлэлт, өрлөгийн ажил хийхэд хугацаа шаардлагатай

Эко автозамын сум, 7-р баг/	хорооллын ажил /БУ	2023.08.02- 2024.07.01	2024.07.01- 2025.06.01	2024.11.28 өдрийн 1/274 бичиг үндэслэн
-----------------------------------	-----------------------	---------------------------	---------------------------	---

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар

3.2.3. Цаашид төсөл, арга хэмжээний гэрээний хугацаа сунгах эсэхийг шийдвэрлэхдээ тендерийн баримт бичигт заасан тохиолдлуудаас бусад тохиолдолд хугацаа сунгахгүй байх, гүйцэтгэгчид гэрээнд заасны дагуу алданги тооцож хэвших шаардлагатай байна.

3.2.4. Нийт төсөл арга хэмжээний 26.8 хувь нь хэрэгжээгүй шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж үзэхэд төсвийн орлого тасарсан, төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээ төсөвт батлагдсаны улмаас худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй зэрэг шалтгаантай байна. Батлагдсан төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байгаа нь төсвийн хөрөнгийн оруулалтын төлөвлөгөөний үр нөлөөг бууруулж, иргэд хөрөнгө оруулалтаас хүртэх үр өгөөжийн хугацаа хойшлох сөрөг үр дагавартай байна.

3.3. Зарим барилга, их засварт чанарын доголдол илэрсэн нь захиалагчийн техник хяналтыг сайжруулах шаардлагатайг харуулж байгаа бөгөөд урсгал засварын зардал нэмэгдэх, ашиглалтын хугацаа богиносх зэрэг сөрөг үр дагавар үүсгэж байна.

3.3.1. Тоног төхөөрөмж худалдан авах төсөл, арга хэмжээнүүдийн хувьд захиалагчийн баталсан техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтийн дагуу комисс ажиллан хүлээн авсан байна.

3.3.2. Ажил гүйцэтгүүлэх төсөл, арга хэмжээний хувьд барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын комиссоор өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжээгүй байхад хүлээн авсан дараах төсөл, арга хэмжээ байна. Тухайлбал

- Сумын Эрүүл мэндийн төвийн засвар /Онгон сум/ төсөл, арга хэмжээний эхийн амрах байрны акустек хавтан солих, өрөө бүрийн шалыг тэгшлүүлэх үүрэг даалгавар хэрэгжээгүй байхад комисс хүлээн авсан.
- Сургуулийн их засвар /Асгат сум/ төсөл, арга хэмжээний барилгын газардуулгын ажиллагааг хэмжүүлэх үүрэг даалгавар хэрэгжээгүй байхад комисс хүлээн авсан.
- Соёлын төвийн дээвэр /Түмэнцогт сум/ төсөл, арга хэмжээний барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын комиссоор өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн хуудас бөглөгдөөгүй.

3.3.3. Ажил гүйцэтгүүлэх зарим төсөл, арга хэмжээний хүрээнд улсын комиссоос өгсөн үүрэг даалгавар бүрэн хэрэгжээгүй байхад барилга байгууламжийг

ашиглалтад хүлээн авсан нь ашиглалтын явцад хүндрэл үүсэх, төсвийн дахин зарцуулалт нэмэгдэх эрсдэлийг дагуулж байна.

3.3.4. Ашиглалтад хүлээн авсан зарим барилга, их засварын ажлуудын хувьд чанарын асуудал үүссэн байна. Тухайлбал дараах төсөл арга хэмжээнүүдийн ашиглалтад хүлээн авсны дараа үүссэн чанарын асуудлыг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 3. Ашиглалтад хүлээн авсан зарим барилга, их засварын ажлын чанар байдал

№	Төсөл арга хэмжээ	Ангилал	Хугацаа	Чанар байдал
1	100-н ортой хүүхдийн дотуур байрны барилга /Сүхбаатар сум/	Барилга байгууламж	2022-2024	Хана цуурч, суулт үүссэн, хаалганы бариул эвдэрсэн, бүх өрөөний агааржуулалтын хамгаалалтын тор нь унасан, 1 өрөөний дээврээс борооны ус гоожсон, шилэн хаалганы доогуур ус урсаж ордог, хүүхдийн өрөөний хана будаггүй тул цэвэрлэж арчих боломжгүй, хананд наасан плита унасан, агааржуулагчаар хүйтэн салхи нэвт үлээдэг, зүүн талын шатны дунд хэсэгт суулт өгч цуурсан, охидын өрөөний шүршүүр эвдэрсэн, ус нь тал цоргоор гардаг.
2	Сумын засвар сум/ ЭМТ /Онгон	Их засвар	2024	Ханын будаг давхарлаж будаагүй, дээвэр гоожсон
3	Сургуулийн засвар /Уулбаян сум/	Их засвар	2023-2024	Биеийн тамирын заалны дээврээс ус гоождог, урлаг заалны паркет шалны өнгөн хэсэг халцарсан, үзэмж муудсан. Мөн урлаг заалны тайз хэсэгт засвар хийгдээгүй, хоолны заалны ерөнхий тэжээлийн утас шитүүдийг шалан дээр байрлуулсан нь жигнүүрийн ус, тогооны ус гоожиход гал гарах эрсдэлтэй байна.

Эх сурвалж: Ашиглагч байгууллагуудаас ирүүлсэн албан бичиг, аудитын ажиглалт

3.3.5. Цаашид чанарын асуудлыг гүйцэтгэгч компаниудаар цаг алдалгүй, хурдан шуурхай засварлуулж, ашиглагч байгууллагын санал, гомдлыг бүрэн шийдвэрлэж хэвших шаардлагатай байна.

3.4. Данс бүртгэлд тусгаагүй зарим төсөл, арга хэмжээнүүдийг бүртгэх талаар зөвлөмжийг санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн байна.

3.4.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 82 төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс хэрэгжиж дууссан 50, хэрэгжилт дутуу 10, хэрэгжээгүй 22 төсөл, арга хэмжээ байна.

3.4.2. Хэрэгжиж дууссан 50 төсөл, арга хэмжээнээс 27 төсөл, арга хэмжээг 10,204.9 сая төгрөгөөр ашиглагч байгууллага бүрийн санхүүгийн тайлангийн бараа материал

болон үндсэн хөрөнгийн данс бүртгэлд тусгасан ба бусад 23 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг урсгал зардлаар бүртгэсэн байна.

3.4.3. Данс бүртгэлд тусгаагүй Сүхбаатар сумын Эрүүл мэндийн төвийн хүүхдийн өрөөний тохижилтын ажлыг 9.9 сая, Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн Номын сангийн тохижилтын ажлыг 9.8 сая төгрөгөөр тус тус данс бүртгэлд тусгах тухай зөвлөмжийг Эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн байна.

---o0o---

Холбогдох байгууллагын санал:



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Сүхбаатар, Баруун-Урт, 7-р баг, Нутгийн удирдлагын
ордон

Утас: 70510111, Факс: 70510111

Цахим шуудан: admin@sukhbaatar.gov.mn

Цахим хуудас: Sukhbaatar.gov.mn

2025.05.30 № 01/592

танай _____-ны № _____-т

「СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

「 Хариу тайлбар хүргүүлэх тухай 」

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилтэнд хийсэн аудитын дүгнэлттэй танилцан дараах тайлбар саналыг хүргүүлж байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүн Ковид 19 цар тахал болон зуд, өвөлжилт, хаваржилтын хүндрэлтэй нөхцөл байдлаас үүдэлтэй удааширч хэрэгжилт саарсан.

Зах зээл дээрх бараа материалын үнийн өсөлт, ажиллах хүчний хомсдолоос шалтгаалж төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд ч хүний нөөцийн хомсдолд орж улс даяар хүний нөөц, ажиллах хүчээ хэрхэн тогтоон байршуулах уу гэдэгтэй нүүр тулсан амаргүй цаг үед аймаг орон нутгийн нийгэм эдийн засгийн нөхцөлөө сайжруулах, хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хэрэгцээ шаардлагыг ханган биелүүлэх, нийгмийн бүхий л салбарын хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлж батлагдсан төсөл арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх, гадны төсөл, хөтөлбөрийг аймаг орон нутагтаа татах зэргээр бүхий л салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхээр хичээнгүйлэн ажиллаж байна.

Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийг бид холбогдох агентлаг, төрийн албан хаагчдад танилцуулж дүгнэлт хийж, алдаа зөрчлийг арилгуулах, танай байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллах болно.



Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газар
Удирдлага
Сүхбаатар аймгийн Засаг дарга
Манлайбаатар Идэрбат
2025-05-30 17:02:54

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

“Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайлангийн төсөлд Сүхбаатар аймгийн Засаг даргын 2025.05.30-ны өдрийн 01/592 тоот албан бичгээр хариу ирүүлсэн. Ирүүлсэн албан бичигт аудитын зарим дүн, дүгнэлттэй холбоотой тайлбар ирүүлсэн байх тул аудитын тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад хувийн өмчид шилжих зарим төсөл, арга хэмжээг тусгаж, баталсан нь Төрийн хэмнэлтийн тухай болон Төсвийн тухай хуультай нийцэхгүй байна.
2. Тендерийн баримт бичигт алдангийн хувь хэмжээг оновчтой тусгаагүйгээс гэрээний хугацааг үндэслэлгүй сунгах, алданги тооцохгүй байх зөрчил нийтлэг байна.
3. Ажил гүйцэтгэх төсөл арга хэмжээний материал, тээвэр, машин ашиглалтын шууд зардлын төсвийг ажлын үе шат бүрээр гаргаж ирүүлэх шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж өгдөггүй нь төсөл арга хэмжээний бодит гүйцэтгэлд тавих шат шатны хяналтын үр нөлөөг бууруулахаар байна.
4. Тендерийн төсвийг нэгж үнээр гаргаж ирүүлээгүй, үнэлгээний хороо хяналтын төсвийн нэгж үнэтэй нийцсэн эсэхийг үнэлдэггүйн улмаас ажил гүйцэтгүүлэх төсөл арга хэмжээний эхний үе шатны ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлээс илүү олгох сөрөг үр дагаврыг бий болгож байна.
5. Захиалагч болон захиалагчийн техник хяналт хэрэгжүүлэгч нар ажил гүйцэтгүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж, бодит гүйцэтгэлээс илүү санхүүжилт олгож байна.
6. Улсын комисс нь үүрэг даалгавар биелээгүй байхад акт, дүгнэлт үйлдэж авто зам, барилга байгууламжийг хүлээн авч байгаа нь авто зам, барилгын чанарт сөргөөр нөлөөлж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-т:

1. Тендерийн баримт бичигт алдангийн хувь хэмжээг бизнесийн зээлийн өдрийн дүнд нийцүүлэн бодитоор тусгах, гэрээний хугацаа сунгах үндэслэлгүй тохиолдолд алданги тооцох механизмыг хэвшүүлэх. Мөн нэгж болон нийт

үнийн хяналтын төсвийг цахим системд бүрэн оруулж, үнэлгээний хорооноос заавал шалгаж дүгнэх хяналтын механизм бүрдүүлэх.

2. Ажил гүйцэтгэх хуваарийн дагуу захиалагчийн хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэн, тендерийн баримт бичигт заасан үндэслэлүүдээс бусад тохиолдолд гэрээний хугацааг сунгалгүйгээр алданги тооцож, гүйцэтгэгч компаниудыг хариуцлагажуулах.
3. Ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын баримт бичигт материал, тээвэр, машин ашиглалтын шууд зардлын төсвийг ажлын үе шатаар гаргаж ирүүлэх шаардлагыг тендерийн баримт бичигт тусгасан эсэхэд хяналт тавьж, төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих захиалагчийн техник хяналт болон дотоод хяналтыг сайжруулах.
4. Санхүүжилтийг зөвхөн бодит ажлын гүйцэтгэлд үндэслэн олгох, ашиглалтад хүлээн авахдаа улсын комиссын үүрэг даалгаврыг бүрэн биелүүлсэн эсэхийг нотлох баримтаар баталгаажуулах, чанарын асуудлыг шуурхай арилгуулах хяналтын тогтолцоог сайжруулах, бүрдүүлэх.

Сүхбаатар аймгийн Худалдан авах ажиллагааны газарт:

1. Тендерийн төсвийг нэгж болон нийт үнээр гаргаж ирүүлээгүй оролцогч нарыг үнэлгээний хороо шалгаруулахгүй байх, мөн нэгж үнээр бэлтгэж ирүүлсэн төсвийг магадлалаар баталгаажсан нэгж үнийн төсөвтэй нийцсэн эсэхийг үнэлж, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 26.4.2 дахь заалтыг мөрдөж ажиллах.

---oOo---